

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налайхын Дулааны станц ТӨХК- ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын Хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/001/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал Утас: 7007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 315558 Цахим хаяг: altantsetseguya@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхдэлгэр Утас: 325093 Цахим хаяг: Munkhdelgerd@audit.gov.mn Аудитор: Б.Тэгшлхам Утас: 325093 Цахим хаяг: tegshlkhamb@audit.gov.mn</p>
<p>ᠨᠠᠯᠠᠶᠢᠬᠡᠨ</p>	<p>ᠨᠠᠯᠠᠶᠢᠬᠡᠨ</p>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	7
4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	8
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал:	8
Дараагийн аудитаар биет бус хөрөнгө газар, программ хангамжийн бүртгэл, ашиглалтын үр дүнг үнэлэх нь зүйтэй гэж үзлээ.	8
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.05.13 № 613
танай _____-ны № _____-т

НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.ЭНХТҮВШИН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Налайхын Дулааны станц ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Компанийн нийт хувьцааны 66 хувийг Эрчим хүчний яам, 34 хувийг Эрчист Монгол ХХК тус тус эзэмшиж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тус компани нь 2025 онд 101.9 мян.гкал Дулааны эрчим хүчийг үйлдвэрлэн, дотоод хэрэгцээнд 2.5 мян.гкалыг хэрэглэж, 99.4 мян.гкалыг түгээж, дулаан үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 100.6 хувьтай биелүүлсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

C:\Users\narangua\Desktop\2026\20260513\20260513\20260513\2026.docx 1426050597

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	31,643,095.03	58,119,385.25
1.1.02	Дансны авлага	206,121,359.80	382,095,111.08
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	23,521,176.40	93,186,188.02
1.1.06	Бараа материал	399,514,392.93	184,595,654.61
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	3,700,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	660,800,024.16	721,696,338.96
1.2.01	Үндсэн хөрөнгө	8,939,792,180.74	8,409,219,971.15
1.2.02	Биет бус хөрөнгө	2,456,315,333.41	2,443,661,333.96
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,396,107,514.15	10,852,881,304.56
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,056,907,538.31	11,574,577,643.52
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1.1.01	Дансны өглөг	660,736,207.82	473,516,487.36
2.1.1.03	Татварын өр	250,391,791.47	10,101,277.55
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	48,038,417.75	53,062,415.31
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	31,204.00	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	959,195,342.73	536,680,180.22
2.2	Өр төлбөрийн нийт дүн	959,195,342.73	536,680,180.22
2.3.01	Өмч: - төрийн	8,703,255,561.66	8,703,255,561.66
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,727,654,260.64	2,727,654,260.64
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	3,835,859,163.36	3,835,859,163.36
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-4,169,059,068.39	-4,228,871,522.36
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	25,403,667.86	-58,627,565.88
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-4,194,462,736.25	-4,170,243,956.48
2.3.11	Эздийн өмчийн дүн	11,097,712,195.58	11,037,897,463.30
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,056,907,538.31	11,574,577,643.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
01	Борлуулалтын орлого (цэвэр)	5,342,985,163.92	8,422,506,529.97
02	Борлуулалтын өртөг	8,911,465,743.24	11,058,065,944.77
03	Нийт ашиг(алдагдал)	-3,568,480,579.32	-2,635,559,414.80
04	Түрээсийн орлого	2,945,454.60	2,945,454.60
05	Хүүгийн орлого	1,653,043.53	993,256.16
08	Бусад орлого	263,067,543.54	399,728,207.61
08.1	Орлогын дүн	240,666,041.67	403,666,918.37
10	Ерөнхий ба удирдлагын зардал	351,534,357.26	485,859,672.62
12.1	Зардлын дүн	351,534,357.26	485,859,672.62
17	Бусад ашиг (алдагдал)	3,711,586,313.74	2,659,124,603.17
17.1	Олз, гарзын дүн	3,711,586,313.74	2,659,124,603.17
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	32,237,418.83	-58,627,565.88
19	Орлогын татварын зардал	6,833,750.97	

20	Татварын дараах ашиг (алдагдал)	25,403,667.86	-58,627,565.88
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	25,403,667.86	-58,627,565.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,871,967,545.41	13,019,745,631.48
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,392,743,515.87	9,496,345,444.02
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	4,958,806.00	15,557,722.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	4,425,505,000.00	3,300,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	48,760,223.54	207,842,465.46
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,786,569,853.67	12,754,435,352.51
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,351,607,208.51	4,742,564,066.67
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	947,363,929.56	1,300,463,775.37
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	360,528,834.31	325,072,396.49
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	3,013,402,242.55	1,072,314,121.46
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,506,692,425.11	3,274,685,680.46
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	971,100,718.35	1,492,997,848.86
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,160,000.00	478,224.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	633,714,495.28	545,859,238.82
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	85,397,691.74	265,310,278.97
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,609,229.99	993,256.16
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,609,229.99	993,256.16
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	74,561,690.92	238,357,089.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	74,561,690.92	238,357,089.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-72,952,460.93	-237,363,832.84
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	12,445,230.81	26,476,290.22
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,197,864.22	31,643,095.03
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,643,095.03	58,119,385.25

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Налайхын Дулааны станц ТӨХК- ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Үзүүлэлт	Төрийн өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	8,703,255,561.66	2,727,654,260.64	1,952,180,999.37	4,261,540,730.67	9,121,550,091.00
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	67,080,272.73	67,080,272.73
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	1,883,678,163.99
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	25,403,667.86	25,403,667.86
2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	8,703,255,561.66	2,727,654,260.64	3,835,859,163.36	4,169,056,790.08	11,097,712,195.58
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-1,187,166.40	-1,187,166.40
Залруулсан үлдэгдэл	8,703,255,561.66	2,727,654,260.64	3,835,859,163.36	4,170,243,956.48	11,096,525,029.18
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-58,627,565.88	-58,627,565.88
2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	8,703,255,561.66	2,727,654,260.64	3,835,859,163.36	4,228,871,522.36	11,037,897,463.30

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх оны мөн үе	2025 оны		Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<i>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт, борлуулалт</i>						
	Дулаан үйлдвэрлэлт	мян.Гкал	99.1	101.3	101.9	2.8	0.6
2	Нийт орлого	мян.төг	5,583,651.2	9,341,410.7	8,826,173.4	3,242,522.2	-515,237.3
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	5,344,286.4	9,051,410.6	8,422,506.5	3,078,220.1	-628,904.1
	Хүүгийн орлого	мян.төг	1,653.0	0.0	993.3	-659.8	993.3
	Бусад орлого /Маягт, тендер техникийн нөхцөл, үнсний, алданги торгуулийн, угаалгын, засвар үйлчилгээний орлогууд/	мян.төг	237,711.8	290,000.0	402,673.7	164,961.9	112,673.6
3	Нийт зардал	мян.төг	9,574,600.2	13,222,977.0	11,884,801.0	2,310,200.8	-1,338,176.0
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	217,763.1	310,660.2	345,116.0	127,353.0	34,455.8
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	-3,997,782.7	-3,881,566.3	-3,058,627.6	939,155.2	822,938.7

Налайхын Дулааны станц ТӨХК- ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	Улсын төсвийн татаас	мян.төг	4,023,186.4	3,000,000.0	3,000,000.0	-1,023,186.4	0.0
5	Цэвэр ашиг, алдагдал	мян.төг	25,403.7	-881,566.3	-58,627.6	-84,031.2	822,938.7
6	<i>Төсвийн төлбөрт нийт дүн</i>	мян.төг	1,950,105.3	2,957,707.2	2,846,416.1	896,310.8	-111,291.1
	а/ ААНОАТ	мян.төг	0.0	0.0	6,572.9	6,572.9	6,572.9
	б/ НӨТ	мян.төг	652,331.3	892,722.1	916,466.7	264,135.4	23,744.5
	в/ НДШ	мян.төг	947,363.9	1,479,526.8	1,300,638.9	-310,408.7	148.7
	г/ ХАОАТ	мян.төг	332,242.6	569,048.8	604,077.1	271,834.5	35,028.3
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	9,870.8	9,870.1	9,870.8	0.0	0.7
	е/ Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	727.5	529.1	943.1	215.6	414.0
	ж/ Бусад татвар /Газрын төлбөрт/	мян.төг	700.6	1,752.0	3,969.5	3,268.9	2,217.5
	з/ Агаарын бохирдлын татвар	мян.төг	3,472.0	2,451.0	3,472.0	-1,021.0	141.7
	и/ Ус бохирдуулсны татвар	мян.төг	3,396.6	1,807.4	352.2	-3,044.4	-1,455.2
7	Төрийн өмчийн ногдол ашигт	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	0.0
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	113.0	123.0	113.0	0.0	-10.0
9	Нийт цалингийн сан	мян.төг	3,712,099.1	5,708,302.5	5,265,353.4	1,553,254.3	-442,949.1
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	2,737.5	3,867.4	3,883.0	1,145.5	15.6
11	Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	төг	93,444.5	126,432.9	113,668.1	20,223.6	-12,764.8
12	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	1.79	1.46	1.41	-0.4	0.0
13	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	мян.төг	84,233.0	129,461.0	84,233.0	45,228.0	65.1
14	Нийт авлага	мян.төг	229,642.5	95,600.0	478,981.3	249,338.8	383,381.3
	Үүнээс: Найдваргүй	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	
15	Нийт өглөг	мян.төг	959,197.6	304,523.4	536,680.2	-422,517.4	232,156.8
	Үүнээс: Богино хугацаат	мян.төг	959,197.6	304,523.4	536,680.2	-422,517.4	232,156.8
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Налайхын Дулааны станц ТӨХК нь үйл ажиллагааны чиглэлээ “*Дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, тусгай зөвшөөрлийн хүрээнд хэрэглэгчдэд дулаан эрчим хүчийг батлагдсан үнэ тарифаар худалдан борлуулж ажиллана*” гэж тодорхойлжээ.

Налайхын Дулааны станц ТӨХК-ны 2025 онд дэвшүүлсэн зорилго: *“Хэрэглэгчдийн өсөлтийг хангаж, үйлчилгээгээ хүртээмжтэй, чанартай болгох, ашиглалтын найдвартай байдлыг нэмэгдүүлэхийн тулд хүчин чадлаа өргөтгөх, цаашлаад дулаан цахилгааны хосолсон эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох”* гэж тодорхойлсон байна.

4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд иж бүрэн, хугацаандаа байршуулсан, Төрийн хэмнэлтийн тухай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал:

Дараагийн аудитаар биет бус хөрөнгө газар, программ хангамжийн бүртгэл, ашиглалтын үр дүнг үнэлэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,455.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 20,455.9 мянган төгрөгийн 1 алдааг залруулсан байна.

Аудитаар нийт 83,083.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 45,387.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 37,695.6 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 83,083.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дуусаагүй барилга засварын зардлаас үндсэн хөрөнгөнд капиталжуулж бүртгэсэн журналын бичилт 20,455.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	20,455.9			1	20,455.9	1	20,455.9				
Дүн	1	20,455.9			1	20,455.9	1	20,455.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урьдчилж орсон орлого дансанд бүртгэлтэй 36.494.7 мянган төгрөг нь төсөвт байгууллагаас илүү шилжүүлсэн үйлчилгээний төлбөр ба түүнийг суутган тооцож, буцаан шилжүүлээгүй, төсвийн шууд захирагчдад төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх нөхцөл боломжийг дэмжсэн байна. (БН дүүргийн тойргийн ШТГ 16,525.7 мянган төгрөг, НД-ийн ЦХ 15,864.6 мянган төгрөг, НД-ын 331 дүгээр цэцэрлэг 3,748.2 мянган төгрөг, НД-ийн ШШГХ 356.0 мянган төгрөг)	1	36,494.7	1	36,494.7								
Эрх бүхий дээд албан тушаалтны шийдвэр гараагүй, ээлжийн амралтын олговор, цалин давхардуулан 8,892.9 мянган төгрөг олгосон байна.	1	8,892.9	1	8,892.9								

Анхны өртгөө 2005 оноос хойш нөхөж үлдэгдэл өртөггүй болсон 1,472,455.6 мянган төгрөгийн 227 нэр төрлийн 232 хөрөнгийг акталж устгаагүй, цаашид ашиглах хугацаа, үнэ үнэлгээг дахин үнэлээгүй, холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлээгүй байна.	1	-					1	-				
Шатахууны зарцуулалтыг жолоочийн замын тооцооны хуудсаар тооцож үнэлээгүй, эд хариуцагчаас жолоочид олгосон шатахууны 71,415.5 мянган төгрөгөөр зардалд тооцон бүртгэсэн гээр зардалд тооцон бүртгэсэн байна.	1	35,708.0					1	35,708.0				
Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах албан даалгаврын хэрэгжилтийг хангаагүй 1,987.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авсан байна.	1	1,987.6					1	1,987.6				
Хөрөнгийн жилийн эцсийн тооллогын үр дүнг нэгтгэж тооцоо бодсон акт үйлдээгүй байна.	1	-					1	-				
Дүн	6	83,083.2	2	45,387.6			4	37,695.6	-	-	-	-



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 05 дугаар сарын 13

№ 157/А0226181

Улаанбаатар хот

УТАГ-2026/001/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Налайхын Дулааны Станц Төрийн өмчит хувьцаат компаний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Урьдчилж орсон орлого дансанд бүртгэлтэй 36,494,728.00 (гучин зургаан сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга долоон зуун хорин найман) төгрөг нь төсөвт байгууллагаас илүү шилжүүлсэн үйлчилгээний төлбөр ба түүнийг суутган тооцож, буцаан шилжүүлээгүй, төсвийн шууд захирагчдад төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх нөхцөл боломжийг дэмжсэн байна. Үүнд: Багануур дүүргийн тойргийн Шүүхийн Тамгын газар 16,525,726.43 төгрөг, Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс 15,864,853.34 төгрөг, Налайх дүүргийн Хүүхдийн 331 дүгээр цэцэрлэг 3,748,176.35 төгрөг, Налайх дүүргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс 355,972.14 төгрөг байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий 4 төсвийн байгууллагаас дулааны үйлчилгээнд илүү шилжүүлсэн нийт 36,494,728.00 (гучин зургаан сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга долоон зуун хорин найман) төгрөгийг Налайхын Дулааны Станц Төрийн өмчит хувьцаат компаний гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин, ерөнхий нягтлан бодогч Н.Ууганжаргал нараар төлүүлж, Налайх дүүргийн Төрийн сан банкин дахь НД.татварын бус орлогын MN560090100200400914 дугаар дансанд төвлөрүүлэх;

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110209

2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Налайхын Дулааны Станц Төрийн өмчит хувьцаат компаний гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин, ерөнхий нягтлан бодогч Н.Ууганжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Б.ТЭГШЛХАМ

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 05 дугаар сарын 13

№ 138/АУД-20181

Улаанбаатар хот

НТАГ-2026/001/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Налайхын Дулааны Станц Төрийн өмчит хувьцаат компаний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ээлжийн амралтын олговрыг цалинтай давхардуулан 8,892,900.00 (найман сая найман зуун ерэн хоёр мянга есэн зуу) төгрөг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-т "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цалинтай давхардуулан олгосон ээлжийн амралтын нөхөн олговор 8,892,900.00 (найман сая найман зуун ерэн хоёр мянга есэн зуу) төгрөгийг Налайхын Дулааны Станц Төрийн өмчит хувьцаат компаний гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин, ерөнхий нягтлан бодогч Н.Ууганжаргал нараар төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү торгуулийн орлогын MN440090100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Налайхын Дулааны Станц Төрийн өмчит хувьцаат компаний гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин, ерөнхий нягтлан бодогч Н.Ууганжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Б.ТЭГШЛХАМ

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110211